



**ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ**

2021 оны 02 сарын 10 өдөр

Дугаар A/06

Ховд

Үнэлгээний хороо байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1 дэх заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэх Суудлын авто машин, тоног төхөөрөмж /Мэргэжлийн хяналтын газар/ гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Дарга: Х.Баярлах - Жаргалант сумын Засаг даргын Тамгын газрын дарга

Гишүүдэд: О.Мөнхжаргал - Ховд Их сургуульд багш  
Ц.Нямбаяр - Төрийн бус байгууллагын төлөөлөл  
Г.Сувдаа - Иргэний төлөөлөл

Нарийн бичгийн дарга: Д.Дариймаа - Худалдан авах ажиллагааны албаны мэргэжилтэн

2. Үнэлгээний хорооны гишүүдээс ашиг сонирхолын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдэл авах, тендер шалгаруулалтыг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулан явуулж үр дүнг танилцуулахыг Үнэлгээний хороо /Х.Баярлах/-нд даалгасугай.

3. Дээрх төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагаатай холбоотой бүх баримт бичгээр хадгаламжийн нэгж үүсгэхийг Үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга / Д.Дариймаа /-д үүрэг болгосугай.

ДАРГА



Д.ЭНХБОЛД